

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА



**НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
“EASY FLOW” ХӨТӨЛБӨР**

2 дахь хэвлэл

2023 он





Нэр	НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ "EASY FLOW" ХӨТӨЛБӨР
-----	---

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy flow" хөтөлбөрийн хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ "EASY FLOW" ХӨТӨЛБӨР

Боловсруулсан	Хянасан	Танилцсан	Баталсан
Албан тушаал: НУТА-НЫ ТСХ-ИЙН ДАРГА	Албан тушаал: НУТА-НЫ ДАРГА	Албан тушаал: АНУГ-ЫН ДАРГА	Албан тушаал: ИНУТ-ИЙН ДАРГА
Нэр: Т.АЛТАНЗУЛ	Нэр: Т.БАТБАЯР	Нэр: Э.ТӨРБАЯР	Нэр: Н.БАТСАЙХАН
Гарын үсэг: 	Гарын үсэг: 	Гарын үсэг: 	Гарын үсэг: 
Огноо: 2023.10.16	Огноо: 2023.10.17	Огноо: 2023.10.17	Огноо: 2023.10.18

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
23.10.18

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хэвлэлтийн дугаар: 2/Огноо 2023.10.16

Хяналтын дугаар: 03

Нэмэлт өөрчлөлтийн дугаар: 2

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн дэлгэрэнгүй Document details					
1	Баримт бичгийн нэр Document name	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy flow" хөтөлбөр			
2	Баримт бичгийн зорилго Purpose of the Document	Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, хамтын шийдвэр гаргалтад оролцогч талууд, бүс нутгийн болон хөрш улсуудын нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, урсгал төлөвлөлтийн судалгаа, хөгжлийг нэвтрүүлэх замаар нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг Монгол Улсад бүрэн хэрэгжүүлэхэд оршино.			
3	Баримт бичгийн код Unit Identification	-			
4	Хуудасны тоо Total page	15			
5	Хэлбэр Document Owner	Хэвлэмэл-А4			
6	Хариуцах албан тушаалтан Document Owner	Технологи, судалгааны хэсгийн дарга			
7	Батлагдсан огноо Date approved	2023.10.18			
8	Баталсан байгууллага, албан тушаалтан Approved by	Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга			
9	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал Amendments	2019 Анхны хувилбар 2023 Өөрчлөлт орсон			
10	Баримт бичгийн бүтэц Document Structure	11 бүлэг			
11	Хавсралт	-			
12	Тараагдсан байдал	Хэсэг, албан тушаалтан	Хяналтын дугаар	Хувь	Гарын үсэг
		Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн хэсэг	01	Хяналттай хувь	P.Отгосолзор
		Шуурхай төлөвлөлтийн хэсэг	02	Хяналттай хувь	P.Отгосолзор
		Технологи, судалгааны хэсэг	03	Эх хувь	Атамжур
		Захиргааны мэргэжилтэн	04	Хяналттай хувь	Болгорзор
		Дотоод хяналтын мэргэжилтэн	05	Хяналттай хувь	T.Талчин
	Нийт			5	

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
**ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ**
2023 оны 10 сар 18 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Нэр

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ "EASY FLOW" ХӨТӨЛБӨР

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлт батлагдсан огноо	Товч утга	Өөрчлөлт хийсэн шийдвэр	Өөрчлөлт хийсэн огноо
1		2019	Анхны хувилбар	Шинээр батлагдсан.	
2	1	2023	Бүхэлд нь шинэчлэн найруулсан	Шинэчлэн батлагдсан.	2023.10.16

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

2023 оц 10 сар 16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хэвлэлтийн дугаар: 2/огноо: 2023.10.16

Хяналтын дугаар: 04

Нэмэлт өөрчлөлтийн дугаар: 2

Нэр

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ "EASY FLOW" ХӨТӨЛБӨР

ГАРЧИГ

Бүлэг	Агуулга	Хуудас
	Баталгаажуулалтын хуудас	
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	i
	Өөрчлөлтийн бүртгэл	ii
	Гарчиг	iii
	Тайлбар ба товчлол	1-2
1	Хөтөлбөр боловсруулах үндэслэл	3-5
2	Хөтөлбөрийн зорилго	5
3	Хөтөлбөрийн зорилт	5
4	Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим	5
5	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат	5-6
6	Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	6-9
7	Хүрэх үр дүн	9-10
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт	10
9	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	10-14
10	Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	15
11	Хөтөлбөрийн санхүүжилт	15

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
2023 оны 10 сар 16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хэвлэлтийн дугаар: 2/огноо: 2023.10.16

Хяналтын дугаар: 04

Нэмэлт өөрчлөлтийн дугаар: 2

ТАЙЛБАР БА ТОВЧЛОЛ

EASY гэдэг нь дараах утгуудыг илэрхийлнэ.

EFFICIENT	ҮР АШИГТАЙ
APPROPRIATE	ЗОХИСТОЙ
SAFE	АЮУЛГҮЙ
YIELDED	ӨГӨӨЖТЭЙ

МОНГОЛ ҮГС

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
НБУГ	Нисэх буудлуудын удирдах газар
НМЭ	Нисэхийн мэдээллийн эмхэтгэл
НУТА	Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба
НУТМ	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент
НХУ	Нислэгийн хөдөлгөөний удирдлага
НХУ	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ
НХҮА	Нислэгийн хөдөлгөөний үйлчигээний алба
ОУНБ	Олон улсын нисэх буудал
ОУИНБ	Олон улсын иргэний нисэхийн байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮАЗ	Үйл ажиллагааны заавар

ГАДААД ҮГС

ADP	Air traffic flow management Daily Plan
ADS-B	Automatic Dependent Surveillance-Broadcast
AMAN	Arrival Manager
ANSP	Air Navigation Service Provider
APAC	Asia Pacific
APANPIRG	Asia Pacific Air Navigation Planning and Implementation Regional Work Group
ATFM	Air Traffic Flow Management
ATFM/SG	Air Traffic Flow Management Steering Group
ATM	Air Traffic Management
BANP	Basic Air Navigation Plan
CANSO	Civil Air Navigation Services Organization
CDM	Collaborative Decision Making
CONOPS	Concept of Operations
CTOT	Calculated Take-off Time

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТӨХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

2023.10.16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Doc	Document
DMAN	Departure Manager
EET	Estimated Elapsed Time
EST	Estimated Time
FMU's	Flight Management Units
FIXM	Flight Information Exchange Model
GANP	Global Air Navigation Plan
GDP	Ground Delay Program
IATA	International Air Transport Association
ICAO	International Civil Aviation Organization
NARAHG	North Asia Regional ATFM Harmonization Group
PBN	Performance Based Navigation
RSO	Regional Sub Office
RVSM	Reduced Vertical Separation Minima
SSR	Secondary Surveillance System
SWIM	System Wide Information Management
XML	eXtensible Markup Language

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

2023 он 10 сар 16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

НЭГ. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Агаарын тээвэр хөгжихийн хэрээр агаарын навигацийн үйлчилгээний менежментийг урт хугацаанд аюулгүй, үр ашигтай, үйл ажиллагааг нь жигд, хүртээмжтэй болгох шаардлага тулгарч байгаа бөгөөд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн оновчтой тогтолцоог бий болгож хэрэгжүүлснээр нислэгийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг зөв хуваарилах, агаарын замыг уян хатан, чөлөөт байдлаар ашиглах, агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, нислэгийн хөдөлгөөнийг оновчтой хуваарилах, агаарын зайн ашиглалтыг сайжруулах, хамтын шийдвэр гаргалтыг хэрэгжүүлж нислэгийн урсгалыг үр ашигтай төлөвлөх бодит боломж бүрдэх юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/605 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын навигаци-2024" стратеги төлөвлөгөөний хүрээнд тэргүүлэх чиглэл 1 "Судалгаа, шинжилгээнд суурилсан Нислэгийн хөдөлгөөний менежментийн тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх", тэргүүлэх чиглэл 2 "Агаарын навигацийн системийн нэгдмэл байдлыг хангах техник, технологи", тэргүүлэх чиглэл 3 "Агаарын навигацийн хөгжлийн шаардлагыг хангахуйц өндөр мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөц бүрдүүлэх", тэргүүлэх чиглэл 4 "Агаарын навигацийн үйлчилгээний хамтын ажиллагааг өргөжүүлэх", тэргүүлэх чиглэл 5 "Агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй ажиллагааг сайжруулах", ИНЕГ-ын даргын 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А/228 дугаар тушаалаар батлагдсан "Хил хязгааргүй нисэх-2030" дунд хугацааны стратеги төлөвлөгөөний "Дэлхийн хүн" хөтөлбөрийн хүрээнд мэргэшсэн хүний нөөцийг олон улсын стандарт, шаардлага, өөрийн орны онцлог, эрх зүйн орчинд нийцүүлэн дадлагажуулах, ур чадварыг хадгалах, давтан сургалт болон дахин мэргэшүүлэх сургалтад хамруулах, "Чөлөөт агаарын зай" хөтөлбөрийн хүрээнд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхээр тус тус тусгагдсан.

Монгол Улсын иргэний нисэхийн салбарт дэвшилтэт шинэ техник технологи, бодит ажиглалтын автоматжуулсан системийг нэвтрүүлж, багасгасан босоо зайчлал (RVSM), Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийг хэрэгжүүлэх, бодит ажиглалтын системүүд (SSR, ADS-B)-ээр Монгол Улсыг бүрхэх гэх мэт НХУ-ний чанарыг сайжруулах үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа боловч аюулгүй, үр ашигтай, хурдан шуурхай үйлчилгээгээр ханган ажиллахын тулд Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хамгийн оновчтой шийдлээр хэрэгжүүлэх бодит шаардлага тулгарч байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд Ази-Номхон далайн бүс нутаг болон Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх нислэгийн тоо хурдацтай нэмэгдэж ирсэн нь "Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент"-ийг хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээг бий болгосон боловч дэлхий нийтэд тархсан цар тахлын дараах нөхцөл байдал, геополиткийн асуудлаас шалтгаалан нислэгийн урсгал тоо хэмжээ буурч, агаарын

тээврийн салбарт эдийн засгийн хямрал үүсэж нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажил удааширсан.

Цаашид дэлхийн эдийн засаг сэргэж, агаарын тээврийн үйл ажиллагаа тогтмолжиж нислэг нэмэгдэх үед өсөн нэмэгдэж буй нислэгийн урсгалыг үр ашигтай, аюулгүйгээр удирдан зохицуулахад нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг эрчимтэй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хил залгаа улс орнууд болох ОХУ, БНХАУ-ын зүгээс НУТМ-ийн арга хэрэгслүүдийг авч хэрэгжүүлж байгаа нь Монгол Улсын агаарын зайн багтаамж, нислэгийн хөдөлгөөний менежмент, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд мэдэгдэхүйц нөлөөлж, манай улсын зүгээс НУТМ-ийг авч хэрэгжүүлэх цаг хугацаа нь болсон гэдгийг харуулж байна. Түүнчлэн Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй нислэгийн урсгал нь Европоос эхлэлтэй зүүн азийн чиглэлд ихэвчлэн үйлдэгддэг тул цаашид Бүс нутгийн нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол Улс нь Европ-Азийг холбосон хамгийн дөт, агаарын тээвэрлэгчдэд ашигтай агаарын замуудтай бөгөөд нийт нислэгийн 90 орчим хувийг олон улсын өнгөрөлтийн нислэг эзэлдэг. Иймд НУТМ-ийн олон төрлийн арга хэрэгслүүдээс Монгол Улсад Хил-дамнасан (Cross-Border ATFM), Тархсан олон зангилаат (Multi-Nodal ATFM) НУТМ-ийг хэрэгжүүлэх шаардлагатай.

НУТМ-ийг нислэгийн бүх үе шатанд агаарын зайн багтаамжийг тооцох замаар нислэгийн урсгалыг үр ашигтайгаар төлөвлөн нисэх буудлын оператор, агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэгчид, агаарын зайн хэрэглэгчид, зэвсэгт хүчний эрх бүхий байгууллага гэх мэт бусад оролцогч талуудтай хамтран эрэлт, багтаамжийг тэнцвэржүүлж хэрэгжүүлнэ.

Ази-Номхон далайн бүс нутгийн агаарын зай нь дамжин өнгөрөх нислэгийн хугацаа багатай, харьцангуй жижиг нислэгийн мэдээллийн районууд гэж тодорхойлогддог. Энэхүү бүс нутагт нислэгийн урсгал зохицуулалтыг нэвтрүүлснээр агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, хүний хүчин зүйлээс шалтгаалсан аюулын эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Энэхүү хөтөлбөр нь НУТМ-ийг хэрэгжүүлэх удирдамж болох бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлого, Олон улсын нислэгийн хөдөлгөөний менежмент (АТМ)-ийн алсын хараа, стратеги, хэтийн төлөв хийгээд Ази-Номхон далайн агаарын навигацийн үндсэн төлөвлөгөө (BANP, Doc 9673) Global ATM Operational Concept (Doc 9854), Global Air Navigation Plan (GANP, Doc 9750), НУТМ (Doc 9971-Manual on Collaborative Air Traffic Flow

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛ

ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

2023.10.16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТГАЙ ХУВЬ

Management) болон Global Aviation Safety Plan (GASP, Doc 10004), "Хил хязгааргүй нисэх-2030" дунд хугацааны стратеги төлөвлөгөөг үндэслэн боловсруулсан болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийн зорилго нь нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, хамтын шийдвэр гаргалтад оролцогч талууд, Бүс нутгийн болон хөрш улсуудын нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, урсгал төлөвлөлтийн менежментийн судалгаа, хөгжлийг нэвтрүүлэх замаар НУТМ-ийг Монгол Улсад бүрэн хэрэгжүүлэхэд оршино.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

- 3.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.1.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн судалгаа, хөгжлийг нэвтрүүлэх
 - 3.1.2 Хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэх
 - 3.1.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

- 4.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална: Үүнд:
- 4.1.1 Иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлоготой уялдаатай байх
 - 4.1.2 Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх
 - 4.1.3 Ил тод, нээлттэй байх
 - 4.1.4 Боломжит эх үүсвэр, нөөц бололцоонд тулгуурласан байх
 - 4.1.5 Салбарын ажилтнуудын жигд оролцоог хангасан байх
 - 4.1.6 Үнэлгээний аргачлал үр дүн, үр ашигт суурилсан байх
 - 4.1.7 Хөтөлбөрийн хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан байх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ

- 5.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийг 2030 он хүртэл гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.1.1 Нэгдүгээр үе шат: НУТМ-ийг нэвтрүүлэх 2023-2025 он
 - 5.1.2 Хоёрдугаар үе шат: НУТМ-ийг хөгжүүлэх 2026-2028 он

5.1.3 Гуравдугаар үе шат: НУТМ-ийг бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаанд ашиглах 2029-2030 он

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн судалгаа, хөгжлийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.1.1 Нисэх буудлын болон агаарын зайн эрэлт, багтаамжийг тэнцвэржүүлэх замаар нислэгийн урсгал төлөвлөлтийг үе шаттайгаар боловсронгуй болгох.

6.1.1.1 Нисэх буудлын болон агаарын зайн багтаамжид нийцүүлэн нислэгийн урсгалыг төлөвлөх.

6.1.1.2 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад нислэгийн цагийн ачааллын зохицуулалтыг хийж, төлөвлөх.

6.1.2 Хил дамнасан нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (Cross-Border ATFM) –ийг хэрэгжүүлэх.

6.1.2.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан системийг нэвтрүүлэх /2024-2026 он/.

6.1.2.2 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан системийн үйл ажиллагааг хөгжүүлэх /2027-2028 он/.

6.1.2.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан системийг Бүс нутгийн хэмжээнд өгөгдөл солилцоонд ашиглах /2029-2030 он/.

6.1.2.4 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн мэдээллийг хөрш улсууд болон тархсан олон зангилаат (Multi-Nodal), NARANG-ийн гишүүн улс орнуудтай солилцох.

6.1.2.5 БНХАУ, ОХУ-ын нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагатай Хил дамнасан нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (Cross-Border ATFM)–ийг хэрэгжүүлэх санамж бичиг байгуулах.

6.1.2.6 Мэдээлэл солилцох замаар Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд НУТМ-д оролцох.

6.1.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн системийн техник, технологи, программ хангамжийг шинэчилж, бүс нутгийн болон хөрш улсуудын нислэгийн урсгал төлөвлөлтийн мэдээлэл солилцох FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны үйл ажиллагааг нэвтрүүлэх.

6.1.3.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн өдөр тутмын төлөвлөгөөг хөрш улсуудтай CRV сүлжээгээр солилцох.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТӨХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

2023-10-сая/6-өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хуудас | 6

- 6.1.3.2 Бүс нутгийн болон хөрш улсуудын нислэгийн урсгал төлөвлөлтийн системүүдтэй мэдээлэл солилцох FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны үйл ажиллагааг нэвтрүүлэх, бэлтгэл ажлыг хангах.
- 6.1.3.3 Бүс нутгийн болон хөрш улсуудын нислэгийн урсгал төлөвлөлтийн системүүдтэй мэдээлэл солилцох FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны үйл ажиллагааг нэвтрүүлэх.
- 6.1.4 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн судалгаанд үндэслэн агаарын зайн ангилал, нисэх буудал болон НХУ-ийн секторуудын багтаамж, чадавхыг тодорхойлох.
- 6.1.4.1 Тогтоогдсон агаарын зайн багтаамжид дүн шинжилгээ хийх.
- 6.1.4.2 Монгол Улсын агаарын зайн багтаамжийг шинэчлэн тогтоох.
- 6.1.4.3 Тогтоогдсон нисэх буудлын багтаамжид дүн шинжилгээ хийх.
- 6.2 Хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 6.2.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн хамтын шийдвэр гаргалтын оновчтой механизм бий болгож, оролцогч талуудын үйл ажиллагааг тодорхойлох.
- 6.2.1.1 Хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлох.
- 6.2.1.2 Хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг нэвтрүүлэх.
- 6.2.1.3 Хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг хөгжүүлэх.
- 6.2.2 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын хөгжилд түлхэц үзүүлэх техник туслалцаа авах асуудлаар хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- 6.2.2.1 БНХАУ болон ОХУ-тай хамтын ажиллагааны уулзалт хийх.
- 6.2.2.2 БНХАУ болон ОХУ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулах.
- 6.2.2.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын хөгжилд түлхэц үзүүлэх техник туслалцаа авах асуудлаар хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх.
- 6.2.3 Хөрш улсуудын болон бүс нутгийн нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан мэдээлэл солилцох замаар Ази номхон далайн бүс нутгийн хэмжээнд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментэд оролцох.

- 6.2.3.1 Хөрш улсуудын болон бүс нутгийн нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах.
- 6.2.3.2 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан систем хооронд өгөгдөл мэдээлэл солилцох.
- 6.2.4 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллага болон хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудын түншлэлийг бэхжүүлэх.
- 6.2.4.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын хөгжилд түлхэц үзүүлэх техник туслалцаа авах асуудлаар хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх.
- 6.2.4.2 Хөрш улсууд болон бүс нутгийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагуудтай хамтран ажиллах.
- 6.2.4.3 Өдөр тутмын хамтын шийдвэр гаргах (CDM) уулзалтыг оролцогч талууд /хөрш улсуудын НУТМ-ийн байгууллагууд, агаарын тээвэрлэгчид/-тай зохион байгуулах.
- 6.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 6.3.1 Бүс нутгийн хэмжээнд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэгч байгууллага болох.
- 6.3.1.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн системийн техник, технологи, программ хангамжийг шинэчлэх.
- 6.3.1.2 Тархсан олон зангилаат (Multi Nodal) болон Хил дамнасан (Cross-Border ATFM) НУТМ-ийн сүлжээний мэдээлэл солилцох үйл ажиллагааг дээшлүүлэх.
- 6.3.2 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын ажилтнуудыг нислэгийн урсгал төлөвлөлт, агаарын зайн менежментийн богино хугацааны сургалт, өндөр хөгжилтэй улс орнуудад мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах.
- 6.3.2.1 Гадаад болон дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, агаарын зайн менежментийн богино хугацааны сургалтад үе шаттайгаар хамруулах.
- 6.3.2.2 Гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өндөр хөгжилтэй улс оронд НУТМ-ийн нарийн мэргэшүүлэх сургалтад хамруулах.
- 6.3.2.3 НУТМ-ийн чиглэлээр тэтгэлэгт сургалтад хамруулах.
- 6.3.2.4 НУТМ-ийн үйл ажиллагаанд оролцогч талуудад сургалт зохион байгуулах.

6.3.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх үндсэн шаардлага, хэрэгжүүлэх алхам, шалгуур үзүүлэлтийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг Doc 9971 /Manual on Collaborative Air Traffic Flow Management/-т заасны дагуу тодорхойлох.

6.3.3.1 НУТМ-ийн үйл ажиллагааны заавар боловсруулна.

6.3.3.2 НУТМ-ийн хураангуйг нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP) 1.9-д оруулна.

6.3.3.3 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй холбогдуулан баримт бичгүүдийг боловсруулна.

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

7.1.1 Агаарын зайн багтаамж болон нэгж секторын нэвтрэн өнгөрүүлэх чадвар ихсэж үүний үр дүнд өсөн нэмэгдэж байгаа нислэгийг аюулгүй, дэс дараатай, түргэн шуурхай үйлчилгээгээр хангах боломжийг бүрдүүлнэ.

7.1.2 Монгол Улсын агаарын зайд бүх агаарын хөлгүүд ашигтай өндрөөр нислэг үйлдэх боломжтой болсноор нислэгийн зардлыг бууруулж агаарын тээвэрлэгчдийн үр ашгийг дээшлүүлнэ.

7.1.3 Нэвтрэн өнгөрүүлэх чадвар хэтэрсэн буюу хэтрэх төлөвтэй байгаа нислэгийн урсгалыг ачаалал багатай цагт шилжүүлэх, агаарын зам, өндөр, нислэгийн хөдөлгөөний секторыг өөрчлөх гэх мэт арга хэрэгслүүдийг ашиглан нислэгийн урсгалыг оновчтой хуваарилснаар нислэгийн удирдагч нарын ажлын ачааллыг багасгана.

7.1.4 Хамтын шийдвэр гаргалтын үйл ажиллагааг нэвтрүүлснээр агаарын зайн болон нисэх буудлын багтаамж нэмэгдэн, үйл ажиллагааны үр дүн сайжирна.

7.1.5 Монгол Улсын нутаг дэвсгэрийг тойрон нисэж буй нислэгүүдэд Монгол Улсын агаарын зайг дайран өнгөрөх боломжийг бүрдүүлж, Ази-Европ болон Ази-Америк тивүүдийг холбож буй нислэгийн урсгал нэмэгдэнэ.

7.1.6 Агаарын зайн багтаамжид нийцүүлэн нислэгийн урсгалыг оновчтой төлөвлөснөөр Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх өнгөрөлтийн нислэгийн тоо нэмэгдэн, улсын төсөвт төвлөрүүлдэг агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлого өснө.

7.1.7 Хүлэмжийн хийн ялгаруулалт багасна.

7.1.8 Нисэх буудлын хамтын шийдвэр гаргалтыг хэрэгжүүлснээр нислэгийн цагийн ачааллын зохицуулалт хийгдэж, агаарын хөлгийн саатал болон хоцрогдлыг багасгаж зорчигчид нислэгийн талаарх мэдээллийг цаг тухайд нь авна.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД

ХЯНАЛТГУЙ ХУВЬ

2023.10.16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТГАЙ ХУВЬ

Хэвлэлтийн дугаар: 2/огноо 2023.10.16

Хяналтын дугаар: 04

Нэмэлт өөрчлөлтийн дугаар: 2

- 7.1.9 НУТМ-ийн хамтын шийдвэр гаргалтад оролцогч талууд нь шийдвэр гаргахад шаардлагатай бүхий л мэдээллийг хуваалцах, тасралтгүй шинэчилсэн мэдээллээр хангагдана.
- 7.1.10 Багтаамжид нөлөөлөхүйц аливаа асуудлыг оролцогч талуудтай зөвшилцөж, үр дүнтэй түргэн шуурхай шийдвэрлэх боломж нэмэгдэнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 8.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба хариуцна.
- 8.2 Хөрш улсууд болон бүс нутгийн хэмжээнд НУТМ-ийг хэрэгжүүлэх зорилгоор хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудын төлөөллийг оролцуулан удирдлага, зохион байгуулалтаар хангах удирдлагын багийг бүрдүүлнэ.
- 8.3 Удирдлагын багийн бүрэлдэхүүн нь нислэгийн хөдөлгөөний менежмент, агаарын зайн менежмент, холбооны болон мэдээллийн технологийн менежментээр мэргэшсэн байх шаардлагатай.
- 8.4 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор НУТМ-ийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардагдах сургалтын бодлого, төлөвлөгөөг боловсруулж, нислэгийн урсгал төлөвлөлтийн ажилтнуудыг тогтмол сургаж дадлагажуулах, хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудад НУТМ-ийн мэдлэг олгох сургалтад үе шаттайгаар хамруулах ажлыг зохион байгуулна.
- 8.5 Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын хүний нөөцийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг таниулан мэдүүлэх, сургах, мэргэшүүлэх зэргээр байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн бодлогыг боловсруулж баримтална.
- 8.6 Хүний нөөцийн бодлогыг Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаатай уялдуулан тухай бүр, нарийвчлан боловсруулна.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 9.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойлно.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин			
		2023 оны түвшин	2023-2025 он	2026-2028 он	
1. Нислэгийн урсгал төлөвлөлтийн судалгаа хөгжлийг нэвтрүүлэх зорилт:					
1	Нисэх буудлын болон агаарын зайн эрэлт, багтаамжийг тэнцвэржүүлэх замаар нислэгийн урсгал төлөвлөлтийг үе шаттайгаар боловсронгуй болгох.	Урьдчилсан болон шуурхай төлөвлөлтийн үе шатанд "НУБИЭ" ХХК-тай НУТМ-ийг хэрэгжүүлэн "Чингис хаан" ОУНБ-ын багтаамжид нийцүүлэн нислэгийн урсгалыг төлөвлөж байна.	Нислэгийн төлөвлөлтийн менежментийн шатуудад нислэгийн цагийн ачааллыг зохицуулж, төлөвлөлт хийдэг болсон байна.	Нислэгийн төлөвлөлтийн менежментийн шатуудад хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудтай НУТМ-ийг хэрэгжүүлэн багтаамжид нийцсэн төлөвлөлт хийдэг болсон байна.	НУТМ-ийн автоматжуулсан системийг ашиглан Ази номхон далайн болон бүс нутгийн хэмжээнд НУТМ-ийг хэрэгжүүлэн Нислэгийн урсгал төлөвлөлт боловсронгуй болсон байна.
2	Хил дамнан нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (Cross-Border ATFM) –ийг хэрэгжүүлэх.	Хил дамнан нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (Cross-Border ATFM)-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай НУТМ-ийн автоматжуулсан системийн техникийн шаардлага боловсруулагдсан. БНХАУ, ОХУ-ын нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагатай байгуулах санамж бичгийн төсөл боловсруулагдсан.	НУТМ-ийн автоматжуулсан системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, систем нийлүүлэгдэн суурилагдсан байна.	НУТМ-ийн автоматжуулсан системийг ажиллагаанд өгөгдөл, мэдээлэл солилцож эхэлсэн байна.	БНХАУ, ОХУ-ын нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагатай Хил дамнан нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (Cross-Border ATFM)-ийг хэрэгжүүлэх санамж бичиг байгуулж, тархсан олон зангилаат (Multi-Nodal), NARANG-ийн гишүүн улс орнуудтай мэдээлэл солилцох замаар Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд нислэгийн урсгал төлөвлөлтөд оролцож эхэлсэн байна.

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГУЙ ХУВЬ
В.С.И.В. сэрб. өдөр

Нэр

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ "EASY FLOW" ХӨТӨЛБӨР

3	<p>Нислэгийн төлөвлөлтийн менежментийн урсгал системийн техник, технологи, програм шинэчилж, бүс нутгийн болон хөрш улсуудын нислэгийн урсгал мэдээлэл солилцох FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны үйл ажиллагааг нэвтрүүлэх.</p>	<p>FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны үйл ажиллагаа, стандартыг судалж FIXM-ийг нэвтрүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлагдсан.</p>	<p>НУТМ-ийн өдөр тутмын төлөвлөгөөг хөрш улсуудтай CRV сүлжээгээр солилцож эхлэн, хөрш улсууд болон бүс нутгийн хэмжээнд өгөгдөл, нислэгийн урсгал төлөвлөлтийн системүүдтэй мэдээлэл солилцох FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны үйл ажиллагааг нэвтрүүлэх, бэлтгэл ажлыг хангасан байна.</p>	<p>FIXM суурилсан өгөгдөл солилцооны ажиллагааг хөрш улсууд болон бүс нутгийн хэмжээнд өгөгдөл, мэдээлэл солилцож эхэлсэн байна.</p>	<p>FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцоо үйл ажиллагаанд бүрэн нэвтрэж тогтмолжсон байна.</p>
4	<p>Нислэгийн төлөвлөлтийн менежментийн судалгаанд үндэслэн агаарын зайн ангилал, нисэх буудал болон НХУ-ын секторуудын багтаамж, чадавхыг тодорхойлох.</p>	<p>Агаарын зайн болон нисэх буудлын багтаамж тогтоогдсон.</p>	<p>Агаарын зайн багтаамжид нийцүүлэн агаарын зай, сектор зохион дүн байгуулалтад шинжилгээ хийсэн байна.</p>	<p>Шинээр тогтоогдсон агаарын зай, секторуудын багтаамж тухай бүр шинэчлэн тогтоогдсон байна.</p>	<p>Шинээр тогтоогдсон агаарын зай, секторуудын багтаамж тухай бүр шинэчлэн тогтоогдсон байна.</p>
<p>2. Хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт:</p>					
5	<p>Нислэгийн төлөвлөлтийн менежментийн хамтын шийдвэр гаргалтын оновчтой механизм бий болгож, оролцогч талуудын үйл ажиллагааг тодорхойлох.</p>	<p>Хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудын эрх үүрэг тодорхойлогдсон.</p>	<p>Хамтын шийдвэр оновчтой бий болж, хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг нэвтрүүлсэн байна.</p>	<p>НУТМ-ийн хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг хөгжүүлсэн байна.</p>	<p>Хамтын шийдвэр гаргалтад оролцогч талуудын үйл ажиллагаа тогтмолжсон байна.</p>

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
**ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
 ХЯНАЛТГУЙ ХУВЬ**
 2023.10 сар 8 өдөр

ИНЕГ
 НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
 АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

<p>Нислэгийн төлөвлөлтийн хөгжилд техник асуудлаар олон ажиглалаа өргөжүүлэх.</p>	<p>Дэлхий нийтэд тархсан цар тахлын дараах байдал, асуудлаас засгийн шалтгаалан ОХУ-ын төлөвлөлтийн байгууллагатай бичиг хойшлогдсон.</p>	<p>Нислэгийн төлөвлөлтийн байгууллагын түлхэц үзүүлэх туслацаа асуудлаар болон олон талт ажиглагааг зорилгоор ОХУ-ын төлөвлөлтийн байгууллагатай хамтран ажиллах уулзалт хийх.</p>	<p>БНХАУ нислэгийн төлөвлөлтийн байгууллагатай ажиллах туслацаа боловсруулагдан, хэлэлцэн гэрээ батлагдсан байна.</p>	<p>Хамтран дагуу явагдаж, туслацаа үүрэг гэрээг гэрээг ажиглах гэрээний үйл техникийн авч, гэрээний талууд дүгнэсэн байна.</p>
<p>Хөрш улсуудын нутгийн төлөвлөлтийн байгууллагуудтай ажиглах мэдээлэл Ази нутгийн НУТМ-д оролцох.</p>	<p>Дэлхий нийтэд тархсан цар тахлын дараах асуудлаас засгийн шалтгаалан ОХУ-ын төлөвлөлтийн байгууллагатай бичиг хойшлогдсон.</p>	<p>Хөрш улсуудын нутгийн төлөвлөлтийн байгууллагуудтай мэдээлэл хамтын ажиллагааны гэрээ асуудлаар солилцож боловсруулагдсан байна.</p>	<p>Хөрш улсууд болон нутгийн төлөвлөлтийн байгууллагатай мэдээлэл талаар зөвшилцөж байгуулагдсан байна.</p>	<p>Хөрш улсууд болон нутгийн төлөвлөлтийн байгууллагатай нислэгийн төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан дамжуулан мэдээлэл номхон хэмжээнд оролцож эхэлсэн байна.</p>
<p>Нислэгийн төлөвлөлтийн болон гаргалтад талуудын бэхжүүлэх.</p>	<p>НУТМ-ийн гаргалтыг зорилгоор харьяа 14 аймагтай ажиглагааны журам байгуулсан.</p>	<p>Нислэгийн төлөвлөлтийн байгууллагын түлхэц үзүүлэх туслацаа асуудлаар улсуудын нислэгийн төлөвлөлтийн байгууллагуудтай солилцоно.</p>	<p>НУТМ-ийн автоматжуулсан системийг хамтын хэрэгжүүлэх хөрш улсууд болон нутгийн төлөвлөлтийн байгууллагуудтай ажиллах хангагдсан байна.</p>	<p>НУТМ-ийн системийг тугмын гаргах оролцох улсуудын байгууллагууд, тээвэрлэгчид-тай зохион байгуулдаг болсон байна.</p>

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ALISA

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД
ХЯНАЛТГУЙ ХУВЬ

2023.10.16 өдөр

3. Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилт:					
9	Бус нутгийн хэмжээнд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэгч байгууллага болох.	БНХАУ, БНСУ, Япон Улстай НУТМ-ийн өдөр тутмын төлөвлөгөөг тогтмол солилцож, НУТМ-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн системийн техник, технологи, програм хангамжийг шинэчилж, мэдээлэл солилцох бэлтгэл ажлыг хангасан байна.	Тархсан олон зангилаат (Multi Nodal) болон Хил дамнасан (Cross-Border ATM) НУТМ-ийн мэдээлэл солилцож хөрш улсууд болон бус нутгийн хэмжээнд НУТМ-ийг хэрэгжүүлэгч байгууллага болсон байна.	Тархсан олон зангилаат (Multi-Nodal), хил дамнасан (Cross-Border ATM) НУТМ-ийн мэдээлэл солилцож хөрш улсууд болон бус нутгийн хэмжээнд НУТМ-ийг хэрэгжүүлэгч байгууллага болсон байна.
10	Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын ажилтнуудыг нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, агаарын зайн менежментийн богино хугацааны сургалт, өндөр хөгжилтэй улс орнуудад мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах.	Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2022 онд НУТМ-ийн давтан сургалтад 15 ажилтныг хамруулсан.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, агаарын зайн менежментийн богино хугацааны сургалтад үе шаттайгаар болон өндөр хөгжилтэй улс оронд НУТМ-ийн нарийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, агаарын зайн менежментийн богино хугацааны сургалтад үе шаттайгаар болон өндөр хөгжилтэй улс оронд НУТМ-ийн нарийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, агаарын зайн менежментийн богино хугацааны сургалтад үе шаттайгаар болон өндөр хөгжилтэй улс оронд НУТМ-ийн нарийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.
11	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг тогтолцоог нэвтрүүлэх үндсэн шаардлага, хэрэгжүүлэх алхам, шалгуур үзүүлэлтийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг Doc 9971 /Manual on Collaborative Air Traffic Flow Management/-д заасны дагуу тодорхойлох.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагааны заавар боловсруулагдсан.	НУТМ-ийн хураангуйг тухай бүр Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP) 1.9-д шинэчлэн оруулсан байна.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгүүд боловсруулагдсан байна.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгүүд боловсруулагдсан байна.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛ
ХЯНАЛТГАЙ ХУВЬ

2023.10.16 өдөр

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 10.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх "Easy Flow" хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутамд хийх ба хугацааны хагаст буюу 2025 онд урьдчилсан, 2030 онд эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ.
- 10.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дүнд энэхүү хөтөлбөрт тодотгол хийж болно.

АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- 11.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 11.1.1 Улсын төсөв
 - 11.1.2 Өөрийн орлого
 - 11.1.3 Урсгал зардал
 - 11.1.4 Бусад эх үүсвэр.

---oOo---

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

**ХЭВЛЭГДСЭН ТӨХИОЛДОЛД
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ**

2023 он 10 сар 16 өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБА**ХЯНАЛТТАЙ ХУВЬ**